



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 19 он 11  
сарын 06 өдөр

Дугаар 3Г-2/  
843

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын гишүүн танаас 2019 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 22 тоот албан бичгээр ирүүлсэн асуулгын хариуг үүгээр хүргүүлж байна. Үүнд:

Асуулт 1:

Сүүлийн үед мах, махан бүтээгдэхүүний үнэ, нийлүүлэлтийн асуудал олон нийтийн дунд багагүй бухимдал төрүүлж байна. БНХАУ-ын иргэд, аж ахуйн нэгжүүд хямд үнээр их хэмжээний мах худалдан авч нөөцөлж буй нь эргээд махны зохиомол хомсдол үүсгэн, үнийн хөөрөгдөл бий болгож, дотоодын махны үйлдвэрүүдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж буй талаар иргэд шүүмжилсээр байна. Тиймээс малчид болон хот суурин газрын иргэдийн аль алины эрх ашгийг хохироохгүй байх, махны экспорт, худалдаа, нөөцлөлтийн талаар Засгийн газраас ямар зохицуулалт хийж буй талаар:

Хариулт:

Монгол Улсын Засгийн газар 2019 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн "Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай" 285 дугаар тогтоолыг гарган аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд тогтоолын биелэлтийг ханган ажиллаж байна. Мөн энэ жилийн мал, мах бэлтгэл, дотоодын нөөц бүрдүүлэх талаар зөвлөмж боловсруулан хүргүүллээ.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7, 6.8 дахь хэсэгт заасны дагуу "Стратегийн хүнсийг экспортлох, импортлох зөвшөөрөл олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж Засгийн газрын 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 329 дүгээр тогтоолоор батлуллаа. Журамд дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүнийг стратегийн хүнсэнд оруулж тооцох, мах экспортлох зөвшөөрөлд заасан тоо хэмжээний 10 хүртэл хувийг дотоодын зах зээлд нийлүүлэх, тухайн жилийн мал төллөх болон ургац хураах үед стратегийн хүнсийг экспортлохгүй байх, стратегийн хүнсийг экспортлох, импортлох нэг цонхны бодлогыг хэрэгжүүлэх зэрэг зохицуулалтыг тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

0003851

Дотоодын зах зээл дэх махны хангамжийг нэмэгдүүлэх, малаас гарч буй дайвар бүтээгдэхүүн, түүхий эдийн боловсруулалт, ашиглалтыг сайжруулах зорилгоор мах экспортлогч аж ахуйн нэгжүүдтэй бодлогын гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар 2019 он гарсаар 13.5 мянган.тн адууны мах, 1045 тн хонь, ямааны мах, 855 тн дайвар бүтээгдэхүүн, дулааны аргаар боловсруулсан махан бүтээгдэхүүн 11.8 мянган тн нийт 27.2 мянган.тн мах экспортолсон байна.

Нийслэлийн хүн амын 2019-2020 оны өвөл, хаврын улирлын махны хангамж, үнийг тогтвортой байлгах үүднээс мал, мах бэлтгэн нөөцлөх, хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдах үүрэг бүхий ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн А/889 дугаар захирамжаар байгууллаа. Тухайн ажлын хэсэг дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Үүнд:

Арилжааны банкны эх үүсвэрээр хэрэгжих, нийслэлийн хүн амын 2019-2020 оны өвөл, хаврын улирлын махны хэрэгцээг хангах мал, мах бэлтгэх, нийлүүлэх, худалдан борлуулах ажилд нийт 14 аж ахуйн нэгж оролцохоор хүсэлтээ ирүүлснийг судлан шалгаж, шаардлага хангаж буй аж ахуйн нэгжүүдийн тухай албан бичгийг арилжааны банкуудад хүргүүлээд байна.

Дундын зуучлалгүй мах борлуулалтыг дэмжих зорилгоор хүнсний зах, худалдааны төвүүдэд түрээсгүй худалдааг зохион байгуулж байгаа бөгөөд 9 дүгээр сарын 25-наас 30-ны хооронд "Мах, хүнсний ногоо, цагаан идээ - 2019" үзэсгэлэн худалдааг Хан-Уул дүүргийн "Лавай" худалдааны төвд зохион байгууллаа. Уг үзэсгэлэн худалдаанд Архангай, Сүхбаатар, Хэнтий, Баянхонгор, Төв, Сэлэнгэ, Өмнөговь, Завхан, Дархан, Увс, Хөвсгөл аймгуудаас 22 хоршоо, 21 малчин, 11 хөдөө аж ахуйн үйлдвэрлэгч нэгжүүд оролцон зах зээлийн үнээс 9.5-22.3 хувийн хямд үнээр нийт 50.0 тн шинэ мах борлуулсан байна. Мөн тус худалдааны төвд Төв аймгийн малчид 10 дугаар сарын 5-наас 10-ны хооронд зах зээлийн үнээс хямд үнээр мах борлуулах ажлыг зохион байгууллаа.

Хүнсний аюулгүй байдлын шаардлага хангасан мах худалдан авах боломжийг бүрдүүлсэн цахим системийг нийт орон даяар хэрэгжүүлэхээр хөдөө аж ахуй, мал эмнэлэг, цагдаагийн байгууллага, бэлтгэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтнуудад сургалт явуулж, техник тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хийж байна. Одоогийн байдлаар 6 аймгийн 15 суманд бүрэн хэрэгжиж байна.

Махны үйлдвэрүүдэд гарч буй хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох үүднээс хууль, хяналт, мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгүүд нийслэл, орон нутагт байнга хяналт, шалгалт тавин ажиллаж байна.

Цаашид нийслэлийн хүн амд эрүүл ахуйн шаардлага хангасан мах нийлүүлэх, үнийг хөөрөгдөхгүй байх зорилгоор 10 дугаар сарын 25-наас эхлэн сум бүрээс 1000 гулууз богийн мах, 11 дүгээр сарын 20-ноос "Идэш" арга хэмжээг зохион байгуулахаар ажиллаж байна.

## Асуулт 2:

Энэ жил улсын хэмжээнд нийт 169,7 мянган малчин өрхөд 67,7 сая мал өвөлжинө. Хөдөө орон нутагт отор нүүдэл хийхэд бэлчээрийн хомсдол бий болж, орон нутгийн удирдлага, иргэдийн хооронд өтөг бууц, бэлчээртэй холбоотой маргаантай асуудал үүсч байна. Тиймээс отроор өвөлжиж, хаваржихад Засгийн газар, салбарын яам ямар зохицуулалт хийж байгаа болон бэлчээрийн даац жилээс жилд муудаж байгааг хэрхэн зогсоох талаар:

## Хариулт:

Цаг уур орчны шинжилгээний газраас гаргасан 2019-2020 оны өвөл-хаврын улирлын бэлчээрийн даац тодорхойлсон дүнгээр нийт нутгийн 60 гаруй хувьд бэлчээрийн даац хүрэлцээтэй, 40 орчим хувьд бэлчээрийн даац хэтэрч гарсан. Ялангуяа Архангай, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Ховд аймгуудын бэлчээрийн даац 3-5 дахин хэтэрсэн судалгаа гараад байна.

Отор, нүүдлийн зохицуулалтыг аймаг дундын отрын бүс, сум дундын отрын бүс, хилийн зурвас, байгалийн тусгай хамгаалалттай газар гэсэн 4 чиглэлээр хийж байна. Урьдчилсан байдлаар аймаг дундын отрын бүсэд 9 аймгийн 1028 өрхийн 592.7 мянган толгой мал, хилийн зурвас газарт 7 аймгийн 2190 өрхийн 1.3 сая толгой мал, тусгай хамгаалалттай газарт 7 аймгийн 2766 өрхийн 2.2 сая толгой мал отроор өвөлжүүлэх гэрээ хэлэлцээрүүд хийгдэж байна.

Бэлчээрийн даацыг тохиромжтой хэмжээнд барих бодлогын түвшинд малыг тооноос чанарт шилжүүлэх, махны экспортыг бууруулахгүй байх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжих, тэжээлийн ургамал тариалалтыг нэмэгдүүлэх бодлого барин ажиллаж байна.

Малын тооноос чанарт шилжих үндэс нь үржлийн ажил үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, малын бүртгэл мэдээллийг хөгжүүлэх бөгөөд энэ онд Малын генетик нөөцийн хуулийн хүрээнд дүрэм, журмуудыг шинэчлэх, аймгуудын үржлийн албадыг багаж, тоног төхөөрөмжөөр хангах ажлууд хийгдэж, бүртгэл мэдээллийн системийг хөгжүүлэх төслийг эхлүүлээ.

Тэжээлийн ургамал тариалалт сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж 45.7 мянган га хүрсэн нь өмнөх оноос 15.0 мянган га-гаар нэмэгдсэн бөгөөд хураан авах ногоон тэжээл 120.0 мянган тн-д хүрч 30.0 мянган тн-оор нэмэгдлээ.

## Асуулт 3:

Аймаг, сумдын аюулгүйн нөөцөд 2019 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 30,8 мянган тонн өвс, 12,1 мянган тонн тэжээл бэлтгэхээс 2,8 мянган тонн өвс, 1,2 мянган тонн тэжээл бэлтгээд байгаа нь өвсний 9,4 хувь, тэжээлийн 10,1 хувийг эзэлж хангалтгүй байгааг хэрхэн шийдвэрлэх талаар:

Хариулт:

Өвөлжилтийн бэлтгэл хангах Засгийн газрын 285 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр ХХААХҮ-ийн сайдын А-275 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөө гарган ажиллаж байна. Ажлын хэсэг өвөлжилтийн бэлтгэлийг газар дээр нь үзэж танилцахаар 10 дугаар сарын 01-нээс эхлэн одоогийн байдлаар 14 аймагт ажиллалаа.

Энэ жилийн хадлангийн ажилд 6655 дугуйт трактор, 3779 тракторын хадуур, 3837 тракторын тармуур, 465 хаман боогч, 613 морин хадуур, 1007 морин тармуур ажилласан.

Малчид 1.3 сая тн. хадлан, 200.0 мянган тн. тэжээл бэлтгэхээс одоогийн байдлаар 855.9 мянган тн. өвс, 198.0 тн. сүрэл, 80.0 мянган тн. ногоон тэжээл, 26.2 мянган тн. гар тэжээл, 36.4 мянган тн давс, хужир бэлтгэсэн нь 70.0 орчим хувийн биелэлттэй байна.

Аймаг, сумын аюулгүйн нөөцөд 30.8 мянган тн. өвс, 12.1 мянган тн тэжээл бэлтгэхээс 9.6 мянган тн өвс, 2.8 мянган тн. тэжээл бэлтгэж 30.0 хувьтай байна. Аймаг, сумын нөөцийн худалдан авалт ид явагдаж байгаа бөгөөд Дорноговь, Өмнөговь зэрэг зарим аймаг өвс, тэжээл худалдан авах хөрөнгөө бэлнээр байршуулсан байна.

Асуулт 4:

Малчдын эрүүл мэндийн асуудал, 0-2 насны вакцинд хамрагддаг хүүхэд, жирэмсний болон эмчийн хяналтад байдаг эх, хүнд өвчтэй хүмүүсийн эрүүл мэндийг онцгойлон анхаарч ажиллах хэрэгтэй байна. Тухайлбал малаа даган өөр аймаг, сумын нутагт өвөлжих иргэдийн эрүүл мэндийн асуудалд хэрхэн анхаарч ажиллах, эмнэлгийн тоног төхөөрөмж, эмийн нөөц, шатахуун гэх зэрэг шаардлагатай зүйлсийн бэлтгэл ажил, төсөв хөрөнгийг хэрхэн шийдвэрлэсэн талаар:

Хариулт:

Эрүүл мэндийн салбар нь ДЭМБ-аас дэвшүүлсэн "Хүн бүрийг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулах", "Хэнийг ч орхигдуулахгүй байх", "Хүн төвтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх" зарчим, зорилтыг хангах, газарзүйн болон санхүүгийн бэрхшээлээс шалтгаалан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамрагдаж чадахгүй байгаа хүн амд хүрч үйлчлэхээр зорин ажиллаж байна.

Энэ хүрээнд эрүүл мэндийн явуулын тусламж, үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг өргөжүүлж, тухайн орон нутгийн хүн амын хэрэгцээнд тулгуурлан, иргэдэд хүрч үйлчлэх явуулын тусламж, үйлчилгээг Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нэгдсэн эмнэлэг, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөр дамжуулан үзүүлж байна.

Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь зөөврийн мобайл оношилгоо, эмчилгээний технологи ашиглан малчдад, ялангуяа отор нүүдлээр яваа малчид, тариаланчид, хөдөлгөөнт хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлж

байна. Алслагдсан болон газар зүйн хувьд саад бэрхшээлтэй орон нутагт амьдарч байгаа тусламж, үйлчилгээнээс орхигдох магадлалтай иргэдэд эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээг хүргэх зорилготой, явуулын “Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн хэрэглээг өргөжүүлэх нь” нэртэй төсөл 4 жилийн хугацаанд 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн нийт 114 анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ төслийн хүрээнд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах сургалтад хамруулж, эмнэлзүйн сурах бичиг, гарын авлагаар ханган ажиллалаа

Эрүүл мэндийн сайдын “Шуурхай мэдээлэл, тохиолдлын удирдлагын тогтолцооны талаар авах зарим арга хэмжээний тухай” 2017 оны А/508 дугаар тушаалаар өвөлжилт хүндэрсэн үед өвөлжилтийн мэдээг аймгийн Эрүүл мэндийн газраас 14 хоног тутам тогтмол авч хяналт тавьж ажиллахаар тусгасан.

Хоёр хүртэлх насны дархлаажуулалтад хамрагддаг хүүхэд, жирэмсний болон эмчийн хяналтад байдаг эх, хүнд өвчтэй хүмүүсийн эрүүл мэндийг онцгойлон анхаарч Эрүүл мэндийн сайдын 2019 оны 9 дүгээр сарын 19-ны өдрийн А/432 дугаар тушаалаар томуугаас сэргийлэх, хүүхдийн дархлааг дэмжих зорилгоор өндөр тунт А аминдэмийг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан, тав хүртэлх насны 390,000 хүүхдэд 40 орчим сая төгрөгний А аминдэмийг энэ 10 дугаар сард түгээлээ.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/451 дугаар тушаалаар эхний ээлжинд 159.500 хүн/тун томуугийн вакцинаар эрсдэлт бүлгийн хүн ам (нийслэлийн 233 цэцэрлэг, 6 асрамжийн төвийн хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд, 65-аас дээш насны ахмадууд, архаг, хууч өвчтэй хүмүүс)-ыг үнэ төлбөргүйгээр дархлаажуулж байна.

Мөн сайн дурын дархлаажуулалтад одоогоор 30,050 хүнийг (18.8%) хамруулаад байна. Өмнөх жилүүдэд томуугийн эсрэг дархлаажуулалтыг жил бүрийн 11 сарын эхээр хийдэг байсан бол энэ онд 10 сарын эхнээс хийж эхэлснээр томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх арга хэмжээг эрт авч хэрэгжүүлж чадлаа.

Томуу, томуу төст өвчний дэгдэлт үүссэн тохиолдолд нэмэлтээр дэлгэх хүүхдийн орны нөөц, ажиллах хүчний нөөц, шаардагдах санхүүгийн тооцоо судалгааг гаргаж, аймаг нийслэлийн Засаг дарга нар, шийдвэр гаргагч, төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 07 тоот албан даалгавраар “Яаралтай тохиолдолд жирэмсэн эмэгтэйд хүндрэл учруулахгүй, оршин суугаа байршилд ойрхон, харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн тусламж үзүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах, жирэмсэн эмэгтэйг угтаж, эрэмбэлэх, шаардлагатай тусламж, үйлчилгээг шуурхай үзүүлэх” чиглэл өгч мөрдөн ажиллаж байна.

Орон нутагт ажиллаж байгаа эх барих, эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нарт эх барихын яаралтай тусламжид анхаарах асуудал, жирэмсэнтэй хавсарсан дотрын өвчний оношилгоо эмчилгээ, томуу томуу төст өвчний үед үзүүлэх тусламж

үйлчилгээ, угаарын хийн хордлогоос жирэмсэн эмэгтэй, нярайг хэрхэн сэргийлэх зэрэг сэдвүүдээр цахим сургалтуудыг зохион байгуулж, 450 гаруй эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулаад байна.

Өвөлжилтийн бэлтгэл ажил, томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 1,105.9 сая төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийн нөөцийг бүрдүүлээд байна. Үүнд: Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, судас тодруулагч, хяналтын монитор, ЭХО-аппарат /зөөврийн/, дуслын автомат шахуурга, тариурын автомат шахуурга, хүчилтөрөгч өтгөрүүлэгч /5л/, даралтын аппарат/ зэрэг болно.

Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор, 2019.08.31-ний байдлаар 232 эрүүл мэндийн байгууллагын 14 нэр төрлийн 2820 эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийгээд байна. Үүнээс Эрүүл мэндийн яамны харьяа 2 байгууллагын 216, Нийслэлийн эрүүл мэндийн газрын харьяа 32 байгууллагын 957, Хөдөө орон нутгийн 122 эрүүл мэндийн байгууллагын 1331, хувийн хэвшлийн 77 байгууллагын 316 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийсэн.

Эрүүл мэндийн сайдын 2019 оны 01/13 өдрийн “Томуу, томуу төст өвчний дэгдэлтийн үед авах зарим арга хэмжээний тухай” 98 дугаар албан даалгаврын хэрэгжилтийг хангах хүрээнд Эм ханган нийлүүлэх 5 байгууллагаас “Томуу, томуу төст өвчний үед хэрэглэх шинж тэмдгийн эмчилгээ болон амьсгалын замын үйл ажиллагаанд нөлөөлөх, шингэн нөхөх эмийн нөөц”-ийн судалгааг нэгтгэн улсын нөөцийн байдлыг шалгасан. 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 158 нэр төрлийн 6,552,451,347 тэрбум төгрөгийн эмийн нөөцтэй байна.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 388 дугаар тушаалаар эрүүл мэндийн бүх шатны байгууллагууд амин чухал эм, эмнэлгийн хэрэгслийн жагсаалтад заасан болон өөрийн эмнэлгийн онцлог, тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн 2 сарын нөөцтэй байхаар заасны дагуу эрүүл мэндийн байгууллагууд тодорхой нөөцийг бүрдүүлэх ажлыг тогтмолжуулан ажиллаж байна. 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар орон нутагт амин чухал эмийн хангамж 82.5 хувьтай байна.

Мөн томуугийн эмчилгээнд шаардлагатай вирусийн эсрэг Тамифлу (Осельтамивир)75мг N10 тунгаар 566 хайрцаг, 45мг №10 тунгаар 1350 хайрцаг ХӨСҮТ-д нөөцөд хадгалагдаж байна. Мөн ДЭМБ-д 5000 хайрцаг Тамифлу (Осельтамивир) эм нэмж авахаар хүсэлт хүргүүлсэн ба бусад эм хангамжийн байгууллага, эмнэлгүүдэд Осельтамивир (Старфлу-75)75мг №10-тай 4532 хайрцаг нөөцтэй байна.

Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газруудад өвөлжилтийн бэлэн байдлыг хангах, эмийн нөөцийг бүрдүүлэн ажиллах талаар 2019 оны 01 дүгээр сарын 23-ны 2/393, 6 дугаар сарын 17-ны өдрийн 8/2722 албан бичгийг хүргүүлэн хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

Эрүүл мэндийн салбар 2019 онд 20 эрүүл мэндийн байгууллагуудын эмнэлгийн түргэн тусламжид 620.2 сая төгрөгийн өртөг бүхий автомашины парк шинэчлэлийг шийдвэрлэсэн. Өвөлжилт хүндэрсэн тохиолдолд ашиглахаар 472.5 сая төгрөгийн өртөг бүхий автомашин хангалтын нөөцийг бүрдүүлээд байна.

Шатахууны нөөц бүрдүүлэлтийн хувьд бүх сумдын шатахууны зардлыг алслалт болон замын бартаат байдлаас шалтгаалан дунджаар 5.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2019 онд шатахууны төсвийг 1.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн. Салбарын хэмжээнд нийт шатахууны зардал 2018 онд 6.2 тэрбум төгрөг байсныг, 2019 онд 7.5 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлснээр тусламж, үйлчилгээний чанарт эерэг нөлөөлөх боломжийг нэмэгдүүлнэ гэж үзэж байна.

#### Асуулт 5:

Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан гэнэтийн тохиолдолд өвс, тэжээл болоод бусад тусламжийн зүйлсийг тээвэрлэх үүрэг гүйцэтгэх Онцгой байдлын алба, алба хаагчийн хувцас, тоног төхөөрөмжийн хангалт бэлэн эсэх

#### Хариулт:

Онцгой байдлын ерөнхий газар, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын алба хаагчдыг 2019 оны 10 сарын 18-ны өдрөөс хүйтний улирлын хувцас хэрэглэлд шилжүүлэхтэй холбогдуулан төсвийн урсгал зардлаар батлагдсан 2.8 тэрбум төгрөгийн 21 төрлийн нормын хувцас хэрэглэлээр бүрэн хангасан.

Онцгой байдлын албаны тусгай тоноглолтой болон аврах ажлын, тээврийн автомашин, техник хэрэгсэлд хүйтний улирлын 10 төрлийн үзлэг шалгалтыг хийсэн.

Төрийн нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар Онцгой байдлын байгууллагын алба хаагчдын тоо, машин техник хэрэгсэл нууцын зэрэглэлд хамаарах тул тоо хэмжээг бичих боломжгүй байна.

Үндэсний аврах бригадад бүртгэлтэй тээврийн машин, техникийн үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг бүрэн хангасан.

Өвөлжилт хүндэрч өвс, тэжээл болон бусад тусламжийн барааг тээвэрлэх үед машин техник хүрэлцэхгүй тохиолдолд Гамшгаас хамгаалах тухай хууль, Засгийн газрын тогтоолоор батлагдсан Дайчилгаа зохион байгуулах журмын дагуу иргэн, хуулийн этгээдийн машин техникийг дайчилж тээвэрлэлтийг зохион байгуулна.

Монгол Улсын Шадар сайд



Ө.ЭНХТҮВШИН